

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын ОНХС-гийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2026/013/НА-СТА-ОНТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 70584207, Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuu@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-7
3. Аудитын илрүүлэлт	7
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	8

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ОНТС	Орон нутгийн тусгай сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.25 № 113

танай _____-ны № _____-т

ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Хэрлэн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн захирагч нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 92.4 хувиар дүгнүүлсэн байна.

2125020229

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	227,316,797.43	752,111,987.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	227,316,797.43	752,111,987.43
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	227,316,797.43	752,111,987.43
3121	Төгрөг	227,316,797.43	752,111,987.43
31211	Төрийн сангийн харилцах	227,316,797.43	752,111,987.43
33	АВЛАГА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
37	УРТ ХУГААЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	227,316,797.43	752,111,987.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	734,796,350.00
41	БОГИНО ХУГААЦААТ ӨР ТӨЛБӨР	-	734,796,350.00
413	Өглөг	-	734,796,350.00
4136	Бусад өглөг	-	734,796,350.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	734,796,350.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	227,316,797.43	17,315,637.43
51	Засгийн газрын хувь оролцоо	227,316,797.43	17,315,637.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	227,316,797.43	17,315,637.43
51210	Өмнөх үеийн үр дүн	242,554,843.00	227,316,797.43
51220	Тайлант үеийн үр дүн	(15,238,045.57)	(210,001,160.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	227,316,797.43	752,111,987.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,919,998,579.42	3,232,397,065.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,000,000.00	7,500,000.00
121002	Өмч хувьчлалын орлого	-	-
122	Тусламжийн орлого	6,000,000.00	7,500,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	6,000,000.00	7,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,913,998,579.42	3,224,897,065.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,913,998,579.42	3,224,897,065.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,375,080.00	401,701,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	2,859,623,499.42	2,823,195,765.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,919,998,579.42	3,232,397,065.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,935,236,825.00	3,442,398,225.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-үндсэн хөрөнгө	2,935,236,825.00	3,442,398,225.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,935,236,825.00)	(3,442,398,225.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(15,238,245.58)	(210,001,160.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,919,998,779.43	3,232,397,065.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,000,000.00	7,500,000.00
122	Тусламжийн орлого	6,000,000.00	7,500,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	6,000,000.00	7,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,913,998,779.43	3,224,897,065.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,913,998,779.43	3,224,897,065.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,375,080.00	401,701,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	2,859,623,699.43	2,823,195,765.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,919,998,779.43	3,232,397,065.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,935,236,825.00	2,707,601,875.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,935,236,825.00	2,707,601,875.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,935,236,825.00	2,707,601,875.00
223001	Бусад хөрөнгө	2,935,236,825.00	2,707,601,875.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,935,236,825.00)	(2,707,601,875.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(15,238,045.57)	524,795,190.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	242,554,843.00	227,316,797.43
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	227,316,797.43	752,111,987.43

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			242,554,843.00		242,554,843.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	242,554,843.00	0.00	242,554,843.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-15,238,045.57		-15,238,045.57
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	227,316,797.43	0.00	227,316,797.43
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	227,316,797.43	0.00	227,316,797.43

Хэрлэн сумын ОНХС-гийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	227,316,797.43	0.00	227,316,797.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-210,001,160.00		-210,001,160.00
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	17,315,637.43	0.00	17,315,637.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,511,244,000.00	2,707,601,875.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,511,244,000.00	2,707,601,875.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,511,244,000.00	2,707,601,875.00
223001	Бусад хөрөнгө	3,511,244,000.00	2,707,601,875.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,511,244,000.00	3,232,397,065.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,895,585,400.00	2,823,195,765.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	2,895,585,400.00	2,823,195,765.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	379,342,600.00	401,701,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	379,342,600.00	401,701,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	227,316,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	227,316,000.00	-
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	9,000,000.00	7,500,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	9,000,000.00	7,500,000.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		227,316,797.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	227,316,797.43	752,111,987.43
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 762.7 сая төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 27,879.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,544.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хууль, тогтоомжийн хэрэгжилт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Илрүүлэлт Хэрлэн сумын 2 дугаар багт хийгдсэн 27.9 сая төгрөгийн тоглоомын талбай барих ажил нь газрын маргаантай асуудлаас болж тухайн ажлыг комисс хүлээн аваагүй байна. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно", 13.3.3 дахь "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "ОНХС-гийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.3 дахь "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль, журамд нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байх.

Өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал:

2. Илрүүлэлт: ААН-д өгөх 734.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн нь улсын төсвөөс ОНХС-гийн санхүүжилтийн эрхийг 2025.12.30 өдөр нээсэн ч зарлагын гүйлгээг хязгаарласнаас зарлагын гүйлгээ хийгдээгүйтэй холбоотой үүссэн байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хэрлэн сумын 2 дугаар багт хийгдсэн 27.9 сая төгрөгийн тоглоомын талбай барих ажил нь газрын маргаантай асуудлаас болж тухайн ажлыг комисс хүлээн аваагүй байна.	1	27,879.8					1	27,879.8
Хэрлэн сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын ААН-д өгөх 734.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна	1	734,796.3					1	734,796.3
Дүн	2	762,676.1					2	762,676.1